- Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх
- Тухайн бодисыг хадгалах үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээгээр 100 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлалаар авч үзвэл 66.6% нь ховор байна. Гэхдээ химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны агаарт нөлөөлж болзошгүй тул нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тохиолдолд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой.

3.3 ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн хэмжээнд хэрэглэгдэх химийн бодисуудаас хөрсний чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр нөлөөлж болзошгүй. Химийн бодис нь газрын хөрсөнд стандартад заасан хэмжээнээс ихээр хуримлагдвал хөрсний ус ургамлаар дамжин нутгийн оршин суугчдын амьдрах орчин, хөрсний бичил биетэн, биосферт муугаар нөлөөлөх тул бодис тус бүрийг тээвэрлэх, хадгалах нөхцөлийг хангах шаардлага тавигдана.

Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас үүсэж болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв.

Үүнд:

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын хадгалалтын горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх.
- Химийн бодис тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлтээс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100% маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор тохиолдох магадлалд орж байна.

3.4 ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

“МСМ Групп” ХХК-ийн Химийн бодисын агуулах нь зөвхөн хадгалалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд агуулахын ажлын байрны барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийг сайтар ханган ажиллах шаардлагатай. Төслийн үйл ажиллагаанаас усны чанар, найрлагад химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас дараах төрлийн нөлөөллүүд үүсэж болзошгүй. Үүнд:

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах.
- Усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд нөлөөлөх.
- Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас усны чанар найрлагад үзүүлэх нөлөөлөл 100 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 66.6% нь ховор тохиолдохоор байна. Тухайн төслийн хувьд анхаарах гол асуудал нь химийн бодисыг тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох нөхцөлтэй байна. Тиймээс химийн бодисын тээвэрлэлт, нийлүүлэлт хийх үедээ татан авчрах, ачиж тээвэрлэх асуудлыг зохих журмын дагуу явуулсан тохиолдолд нөлөөлөл үзүүлэхгүй байх боломжтой байна.

3.5 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөг химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтаас үүдэлтэй нөлөөлөлд автах, доройтох нь бага боловч зарим төрлийн осол аваар, техникийн аюулгүйн ажиллагааны алдаанаас шалтгаалан шууд болон дам сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй байна. Үүнд:

1. Тээвэрлэх болон агуулахад татан авчрах, хадгалалтын горим зөрчигдсөнөөр химийн бодис хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах
2. Осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулах зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын агуулах болон бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтаас ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлал нь ховор байна. Химийн бодисуудын тээвэрлэлт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан тохиолдолд ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл бага юм.

3.6 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулсан тохиолдолд доорх байдлаар амьтны аймагт нөлөөлж болзошгүй юм. Үүнд:

- Бодисыг гадаргууд алдсан тохиолдолд их хэмжээний бодисоор бохирдсон ургамлыг мал, амьтан идсэнээр хордох.
- Алдагдсан бодис хөрсөнд шингэснээр амьтад, бичил биетэн бодисоор хордох, үхэлд хүрэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд дохиолдох магадлал нь ховор байна.

3.7 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Химийн бодисын агуулахад хүний эрүүл мэндэд эрсдэл үүсгэж болзошгүй эх үүсвэр нь нэр бүхий 57 төрлийн химийн нэгдэл агуулсан 95410 тн 31250 ширхэг бүтээгдэхүүн бөгөөд аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй нөхцөлд химийн бодисууд нь эрсдэл үүсгэх шууд эх үүсвэр болно.

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны явцад эрсдэл үүсэх эсэх нь тухайн химийн бодистой харьцан ажиллаж буй хүнээс шууд хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл агуулахад ажиллаж 6 хүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллахаас үүсэж болзошгүй эрсдэл нь шууд хамааралтай юм. Нөгөө талаар эрсдлийн шинж чанар, цар хүрээнээс хамааран агуулахын ажилчид болон Хан-Уул дүүргийн оршин суугчид эрсдэлд өртөгч болно. Ялангуяа химийн бодисуудтай харьцан ажиллах 6 ажилтан илүүтэйгээр өртөж болзошгүй юм.

Аливаа химийн бодисын бохирдол эх үүсвэрээс хөрс, ус, агаарт алдагдаж тухайн орчны ургамал, амьтныг хордуулахаас гадна хүнсний бүтээгдэхүүнд шингэж, хуримтлагдаж тухайн бохирдсон хөрс, ус, агаараар амьсгалах, хүрэлцэх, мөн бохирдсон хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэх зэрэг замуудаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Химийн бодисын бохирдлын хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь бодисын тун хэмжээ, тухайн бодисын шинж чанар, биозадралд орох чадвар, хуримтлагдах чадвар зэрэг хүчин зүйлсээс хамаардаг.

Өөрөөр хэлбэл нэр бүхий 57 төрлийн химийн нэгдэл агуулсан 95410 тн ,31250 ширхэг бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт аюулгүйн дүрмийг сайтар баримталж ажиллахгүй бол ажиллагсдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй. Иймд химийн бодистой харьцаж ажиллах ажилтнууд нь энэ чиглэлийн мэргэжлийн хүн байх заавал шаардлагатай.

Харин химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын явцад хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг нэгтгэн авч үзье.

Үүнд:

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах.
- Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Химийн бодисыг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.
- Химийн бодисыг хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх.

- Химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.
- Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.
- Бодис нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асгарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөл үзүүлэх зэрэг болно.

ДҮГНЭЛТ

Химийн бодисын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн 62.5% нь бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 50% нь ховор тохиолдохоор байна. Харин нийт нөлөөллийн 37.5% нь нөлөөллийн эрчим цар хүрээгээр дунд гэсэн ангилалд орж байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл магадгүй болон боломжтой ангилалд орж байна. Учир нь тус байгууллага нь үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн химийн бодис, бүтээгдэхүүн эсвэл химийн бодис хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх, химийн бодистой харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох, химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах эрсдэлтэй байгаа тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах шаардлагатай. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд химийн бодисын хадгалалтаас хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү химийн бодисын агуулахын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь:

Үйл ажиллагаагаа явуулахдаа байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахад оршино.

- ❖ Байгаль орчны ISO 14001 стандартыг байгууллагадаа хэрэгжүүлж үргэлжлүүлэн баталгаажилтыг олон улсын эрх бүхий гадны байгууллагаар хийлгэх.
- ❖ БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болгох.
- ❖ Ажиллагсад нэг бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд үүргээ биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэнтэй болох.
- ❖ Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцооноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалж, хамгаалах.

- ❖ Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах.
- ❖ Байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажиллагсдад зааварчилгаа өгч сургалт, сургалтын материалаар хангах
- ❖ Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх.

4.1. ЦАГ УУР, УУР АМЬСГАЛААС ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Химийн бодисуудын хадгалалт, тээвэрлэлтийн үед цаг агаарын болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд хадгалж буй агуулах нь доор дурдсан шаардлагуудыг хангасан байх ёстой.

Үүнд:

- Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механик бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисыг долоо хоногт 1 удаа шалгаж хяналтыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх.
- Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах.
- Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.

4.2. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

- Химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсч болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах.
- Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савалгааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянаж, хуучин бодисыг эхэлж ашиглах зарчмыг баримтлах.
- Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах.
- Химийн бодисын агуулахын хадгалах нөхцлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, ялангуяа химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.
- Химийн бодисын агуулахад шатах, гал авалцах эх үүсвэр болон шатамхай, тэсэрч дэлбэрэх эрсдэлтэй бодис, бүтээгдэхүүнийг нэг дотор хадгалахгүй байх зэрэг болно.

4.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

- Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.
- Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх
- Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх зэрэг болно.

4.4. УСНЫ ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

- Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.
- Зарим төрлийн химийн бодис нь усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой зэрэглэлд хамаарах бодис тул химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу явуулах, усан орчинд нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх.
- Химийн бодисын агуулахад химийн бодис, бүтээгдэхүүнийг татан авчрах, хүлээн авах үйл ажиллагааг явуулахдаа хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах ажиллах зэрэг болно.

4.5. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аваар нь голдуу техник, технологийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг. Химийн хортой болон аюултай бодисыг тээвэрлэх болон устгах үеийн аюулгүй ажиллагаа зөрчигдсөнөөс болон ургамлан нөмрөг, ургамалжилтад үзүүлэх сөрөг нөлөөлөл илүү байна. Иймээс химийн бодис тээвэрлэх, хадгалах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй.

4.6. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаа, осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байнга авч байх шаардлагатай.

4.7. ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих.

- Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын даргаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна.
- Ажлын байран доторх бага хэмжээтэй химийн бодис хадгалах зөөврийн агуулахыг шат, аврах гарц, хонгилын эргэлтийн өнцөг, давчуу хонгил гэх мэт хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулах эрсдэлтэй газар болон албан тасалгаа, амрах өрөө, цайны газар, биеийн тамирын өрөө, эмнэлгийн тусламжийн өрөөний ойр байрлуулах, орон сууц, худалдаа үйлчилгээний газрын болон албан байгууллагын байшингийн зоорийн давхарт хадгалахгүй байх.
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан хэрэгжүүлэх.
- Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх.
- Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх.
- Химийн бодисын агуулахад утаа мэдрэгч, галын дохиоллын систем, даралт мэдрэгч болон тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хий зайлуулагч автомат төхөөрөмж суурилуулах зэрэг болно.
- Ажлын нөхцөлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар жил бүр хийлгэх.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ									
1	Агуулахын орчны тоосжилт болон химийн бодисын хадгалалт, ууршилтаас ялгарах хий нь агаар дахь тоосжилт ба чанарын найрлагыг тодорхой хэмжээгээр өөрчлөх боломжтой.	Агуулах болон ажлын байранд тогтмол шинжилгээ хийлгэж, бохирдлыг хянаж байх /жилд 1 удаа шинжилгээ хийх/	Агуулах, гадна орчинд	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу			Үйл ажиллагааны туршид	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 MNS 4585:2016
ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ									
2	Ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой зохицуулалтгүй хаях нь хөрсний бохирдлын гол эх үүсвэр болох	Ахуйн хатуу хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилж, тогтмол хугацаанд зайлуулах	-	-	Гэрээний дагуу	-	-	2023 он Сар бүр	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
3		Агуулахын орчны хөрсний шинжилгээг хийлгэх	БОННУнэлгээний хүрээнд хөрсний дээж авсан	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу			2023 он	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис,

“МСМ ГРУПП” ХХК-ИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
			цэгээс						элементүүдийн ЗДХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ									
4	Галын болзошгүй аюул осол гарах	Агуулахын цахилгаан монтажийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Ажилчид	-	1,000,000	-	1,000,000	2023 он	MNS 5151:2002 “Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй.
5		Агуулахад гал унтраах хор, хэрэгслүүдийг бэлтгэж тавих /гал унтраагуур, элс, хүрз г.м/		-	ҮА-ны зардалд	-	ҮА-ны зардалд	2023 он	
6		Ажилчдын эрүүл мэндийн үзлэг	Ажилчид	-	ҮА-ны зардалд	-	ҮА-ны зардалд	2023 он	
7	Химийн бодистой харьцаж буй ажилтнууд хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж ажиллаагүйгээс эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцас /гутал, резинен бээлий, хамгаалалтын хошуувч г.м/	Ажилчид	-	ҮА-ны зардалд	-	ҮА-ны зардалд	2023 он	
8		Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар ХАБ-ын сургалт зохион байгуулах	Ажилчид	-	1,000,000	-	1,000,000	2023 он	
НИЙТ ЗАРДАЛ				2 000 000 төгрөг					

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Төслийн талбайд мод, бут суулгах	Шар хуайс, хайлаас тарьж ургуулах	Хогийн цэг орчмын сул шороон хөрстэй хэсэгт	ш	10	200,000	2,000,000	2023	Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага Мод тарих аргачилсан заавар
НИЙТ ЗАРДАЛ						2 000 000 төгрөг			

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаагаар түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай. “МСМ групп” ХХК-ийн төслийн байршил, онцлогоос хамаараад түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажил хийгдэхгүй болно.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Химийн бодис тээвэрлэх болон худалдаалах явцад сав баглаа боодол задарч, асгарч болзошгүй.	Химийн бодисыг зөөж, тээвэрлэхдээ мөрлөж өргөхгүй байх, тусгай зөөврийн тэрэг ашиглах	Химийн бодис тээвэрлэх, худалдаалах явцад	-	-	-		Үйлдвэрийн эрүүл ахуй. Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5079-2001.
2	Химийн бодисын хадгалалтын горим зөрчигдсөнөөс буюу хоорондоо урвалд орсноор тэсэрч, гал түймэр гарч болзошгүй	Химийн бодисын хадгалалт, аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулж байх	Ажилчдад	-	2,000,000	2,000,000		Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458 - 2014
3	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Ажилчдад	-	1,000,000	1,000,000		Гамшгаас хамгаалах тухай хууль
НИЙТ ЗАРДАЛ				3 000 000 төгрөг				

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Хатуу хог хаягдлыг Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тай гэрээ байгуулан тогтмол тээвэрлүүлэх	Төслийн хүрээнд	тн	Эко орчин ХХК-тай тохиролцсоноор	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль / 2017/
2	Үйлдвэрийн	Цэцүүх трейд ХХК-тай байгуулсан гэрээний дагуу		кг, тн	Цэцүүх трейд ХХК-тай тохиролцсоноор	-	-	Тухай бүрт нь	
НИЙТ ЗАРДАЛ				20 000 000 төгрөг					

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт №6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Нэгжийн зардал, төг	Давтамж жилд	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний эрүүл ахуй	Ачаа буулгах тавцан	V/15 IX/15	400,000	2	800,000	-	MNS 5850:2019
2	Хөрсний хими, физик шинж чанар			200,000		400,000	-	
3	Хөрсний хүнд металл			250,000		500,000	-	
УСАН ОРЧИН								
4	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Ажилчдын ундны уснаас	VI/15	100,000	1	100,000	“Монгол-Ус” ТӨХК-ийн үнийн дүнгээр тооцлоо.	MNS 4943:2011
5	Ундны усны бүрэн шинжилгээ			100,000		100,000		
6	Ундны усан дахь хүнд металлын агууламж			100,000		100,000		
АГААР								
7	Орчны агаарын чанарын шинжилгээ	Үйлдвэрийн/станцын гадна, дотор агаар	V/15 IX/15	950,00	2	1 900 000	Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн дүнгээр тооцов.	MNS 4585:2016
НИЙТ ЗАРДАЛ				3 900 000 төгрөг				

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №7 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах	Дотоод төлөвлөлтөөр	2023	“МСМ групп” ХХК	-
2	Тухайн жилийн байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг боловсруулж дүгнүүлэх	Дотоод төлөвлөлтөөр	2023	“МСМ групп” ХХК	-
НИЙТ ЗАРДАЛ		50 000 төгрөг			

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Хүснэгт №8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Нийслэлийн Байгаль орчны газар, “МСМ групп” ХХК	Тайлан	Биелэлт тайлан	2023 оны 11-р сарын 1-ний дотор	-	Байгаль орчны газрын мэргэжилтэн, компанийн удирдлагууд	Улаанбаатар хот
2	БОАЖЯамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар	Тайлан	Тухайн жилийн БОМТ	2023 оны 12-р сарын 1-ний дотор	-	“МСМ групп” ХХК-ийн мэргэжилтнүүд	Улаанбаатар хот

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2023 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2 000 000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2 000 000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	20 000 000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3 000 000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3 900 000
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	50 000
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	-
8	НИЙТ ЗАРДАЛ	30 950 000